

КРИПТО

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ**



2025.02.04

Крипто зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- Чехийн Төв Банк Bitcoin нөөцөд авахыг судалж эхэллээ.
- Kraken АНУ дахь 17 койны стэйкинг үйлчилгээг сэргээв. SEC-ийн зохицуулалтын бодлого өөрчлөгдөж, АНУ-д крипто үйлчилгээ үзүүлэх нөхцөл сайжирч эхэлж байна. Энэ нь крипто биржүүдийн хувьд эерэг дохио болов.
- Трампын гаргасан шинэ шийдвэрийн дагуу АНУ анх удаа төрийн хөрөнгө оруулалтын сан байгуулж, Bitcoin-ийг сандаа багтаах магадлалтай гэж ажиглагчид үзэж байна.

АНУ-ын сенатор Синтия Луммис:



"Төрийн хөрөнгө оруулалтын сан байгуулагдах нь Bitcoin-д маш том боломж"

Крипто мэдлэгт:

DeFi гэж юу вэ?

- ❖ DeFi гэдэг нь Decentralized Finance буюу Төвлөрсөн бус санхүү гэсэн үг.
- ❖ DeFi бол хүн бүр банк шиг ажиллаж чаддаг, блокчэйн дээр суурилсан санхүүгийн систем. Энэ нь хурдан, илүү найдвартай, зуучлагчгүй гэсэн үг.
- ❖ Хэрэв та найздаа гадаадаас \$50,000 илгээх гэж байвал банк олон хоногийн дараа шилжүүлж, шимтгэл авна. Харин DeFi ашиглавал шууд, бага зардлаар мөнгөө илгээж болно.

Bitcoin Dominance гэдэг нь криптовалютын нийт зах зээлийн үнэлгээнд Биткойны эзлэх хувийг илэрхийлдэг. Bitcoin Dominance-ийн өндөр хувь нь хөрөнгө оруулагчид Биткойнд илүү итгэлтэй байгааг, харин бага хувь нь альткойнуудад (Биткойноос бусад криптовалют) итгэлтэй байгааг харуулдаг. Одоогийн байдлаар **Bitcoin Dominance** ойролцоогоор **61%** байна.

Golomt_Capital published on TradingView.com, Feb 03, 2025 22:18 UTC-5



БИТКОЙН - BTC



Bitcoin (BTC) \$100,000-ыг давж тогтворжив. Өнгөрсөн долоо хоногт BTC \$106,000 хүртэл өссөн ч Трампын тарифын нөлөөгөөр \$92,000 хүртэл унасан. Харин \$102,000 дээр тогтворжиж, \$103,200-ыг давбал \$107,000 хүртэл өсөх боломжтой.

Golomt_Capital published on TradingView.com, Feb 03, 2025 22:40 UTC-5

Bitcoin / TetherUS, 4h, BINANCE O101,328.51 H101,732.31 L100,534.03 C100,664.78 -663.74 (-0.66%) -663.75 (-0.66%)



TradingView

ЭФИРИУМ - ETH



Ethereum үнэ \$2,500 түвшнээс өсөж, \$2,920 эсэргүүцэлд тулж зогслоо. Хэрэв \$3,000-ыг давбал \$3,120 – \$3,320 хүрэх боломжтой, харин \$2,900-ыг давж чадахгүй бол \$2,650 – \$2,500 хүртэл буурах эрсдэлтэй. MACD өсөх хандлагатай, RSI 50-аас дээш байгаа нь богино хугацаанд өсөх боломж байгааг харуулж байна.

Golomt_Capital published on TradingView.com, Feb 03, 2025 22:42 UTC-5

Ethereum / TetherUS, 4h, BINANCE O2,879.89 H2,888.50 L2,792.22 C2,801.00 -78.90 (-2.74%) -78.90 (-2.74%)



TradingView

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОЛОМЖУУД



ETF нэр	Товчлол	Зорилго
iShares Bitcoin Trust	IBIT	Биткойны үнийн гүйцэтгэлийг дагах
Fidelity Wise Origin Bitcoin Fund	FBTC	Биткойны үнийн гүйцэтгэлийг дагах
Grayscale Bitcoin Trust	GBTC	Биткойны үнийн гүйцэтгэлийг дагах
iShares Ethereum Trust	ETHA	Эфирийн үнийн гүйцэтгэлийг дагах
ARK 21Shares Active Bitcoin Ethereum Strategy ETF	ARKY	Биткойн болон Эфирийн фьючерс гэрээнүүдэд хөрөнгө оруулах
Bitwise 10 Crypto Index Fund	BITW	Тэргүүлэгч 10 криптовалютын үнийн гүйцэтгэлийг дагах
Amplify Transformational Data Sharing ETF	BLOK	Блокчэйн технологийг хөгжүүлж буй компаниудад хөрөнгө оруулах
Siren Nasdaq NexGen Economy ETF	BLCN	Блокчэйн технологийг ашиглаж буй компаниудын гүйцэтгэлийг дагах
First Trust Indxx Innovative Transaction & Process ETF	LEGR	Блокчэйн дэд бүтэц, технологид суурилсан компаниудад хөрөнгө оруулах

Disclaimer | Хариуцлагын мэдэгдэл

Энэхүү тайлан нь зөвхөн мэдээллийн зориулалттай бөгөөд хөрөнгө оруулалтын зөвлөгөө, санхүүгийн зөвлөмж биш юм. Энэхүү мэдээлэл нь зах зээлийн нөхцөл байдал, олон нийтийн эх сурвалж, найдвартай гэж үзсэн мэдээлэлд тулгуурласан боловч түүний үнэн зөв байдал, бүрэн бүтэн байдал, найдвартай байдлыг баталгаажуулах боломжгүй.

Криптовалют болон холбогдох санхүүгийн хэрэгслүүд нь өндөр эрсдэлтэй, үнэ нь зах зээлийн өөрчлөлт, зохицуулалтын өөрчлөлт, зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, бусад олон хүчин зүйлээс хамаарч огцом савлагаанд орж болзошгүй. Өнгөрсөн гүйцэтгэл нь ирээдүйн үр дүнг баталгаажуулахгүй бөгөөд аливаа хөрөнгө оруулалт нь эрсдэл дагуулдаг.

Хөрөнгө оруулагчид аливаа хөрөнгө оруулалт хийхээс өмнө өөрийн санхүүгийн байдал, эрсдэл даах чадвар, хөрөнгө оруулалтын зорилгоо сайтар үнэлж, мэргэжлийн санхүүгийн зөвлөхтэй зөвлөлдөхийг зөвлөж байна. Энэхүү тайлангийн агуулгад үндэслэн гаргасан аливаа шийдвэрээс үүдэн гарах хохирол, алдагдлын хариуцлагыг манай байгууллага хүлээхгүй болно.